



МОНГОЛБАНКНЫ 90 ЖИЛИЙН ОЙН ЛОГОНЫ

УРАЛДААНД ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА

Уралдааны удирдамж:

Монголбанкны түүхт 90 жилийн ой 2014 онд болох гэж байгаатай холбогдуулан энэ үеэр зохиогдох бүх төрлийн арга хэмжээнд бэлэг тэмдэг болгон ашиглах зорилгоор зураач, нийт уран бүтээлчдийн дунд логоны загвар бүтээх уралдаан зарлаж байна.

Уралдаанд ирүүлэх бүтээлд тавигдах шаардлага:

- Лого нь Монголбанкны үйл ажиллагаа, онцлогийг тусгасан сэтгэлгээний өндөр түвшинд хийгдсэн байна.
- Монголбанкны үндсэн логотой уялдсан байна.
- График дизайны мэргэжлийн програм дээр хийгдсэн байна.
- Лого нь өндөр нягтралтай (**300 pixels/inch-с дээш**) байх бөгөөд жижгээс том руу хувиргахад харьцаа алдагдахгүй үндсэн элементүүд тод харагдана.
- Уралдааны бүтээлээ Adobe photoshop программын JPEG өргөтгөлөөр буулгаж, утга санааны тайлбарын хамт communication@mongolbank.mn; javzandulam@mongolbank.mn цахим хаягаар ирүүлэх буюу Монголбанкны бичиг хэрэгт (А байрны 1 дүгээр давхар) 2 тоот өрөөнд **file** хэлбэрээр авчирч өгнө.
- Логоны дизайн нь хар, цагаан болон өнгөт гадаргуу дээр хэвлэгдэхэд тохиромжтой байна.
- Лого нь видео, ном товхимол, сонин сэтгүүл, ил захидал, сурталчилгааны зурагт хуудас болон бусад материалууд дээр хэвлэгдэх боломжтой байна.
- Уран бүтээлчид зөвхөн өөрийн зохиосон дизайнаар оролцох бөгөөд бусдын бүтээл /лого/-ээс хуулсан, санаа авсан, тэдгээрийн элементийг агуулсан бол хүлээн авахгүй.
- Уралдаанд нэг оролцогч хэдэн ч загвараар оролцож болох бөгөөд бүтээл тус бүрийг тайлбарласан байна.

- Овог нэр, холбоо барих утасны дугаар, ажлын болон оршин суугаа хаягаа уралдаанд ирүүлж буй бүтээлийнхээ тайлбар хэсэгт тодорхой бичсэн байна.

Хүлээн авах хугацаа:

2013 оны 05 дугаар сарын 17-ноос 27-ны хооронд

Шалгаруулалт

Бүтээлийг хүлээн авах сүүлчийн хугацаанаас хойш ажлын 5 хоногт багтаан шалгаруулж, www.mongolbank.mn цахим хуудсаар нийтэд зарлана.

Шагнал:

Хамгийн шилдэг нэг бүтээл **300.000** төгрөгийн мөнгөн шагналтай. Мөн онцгой сайн 2 бүтээлийг Монголбанкны тусгай шагнал, дурсамжийн зүйлээр урамшуулна.

Уралдааны талаар лавлах утас: 310081, 327048